



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭС

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН НЭГДСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь тус газрын 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Холбогдох бодлогын баримт бичиг, эрх зүйн акт болон Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, агентлагийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал өгч ажиллалаа.

ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг буюу Алсын хараа 2050, Монгол Улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайланд тулгуурлан Засгийн газрын 2025 оны 43, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн

төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу 3 багц, 4 үзүүлэлтээр дүгнэв.

2025 онд төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн биелэлт, үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээгээр 97.5 хувь буюу 5 оноотой үнэлэгдлээ. Тус газар нь 2024 онд 94.3 хувь, 4.71 оноотой үнэлэгдсэн бол 2025 онд буюу 3.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны үйл ажиллагааны үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

Үзүүлэлт		Үнэлгээ (хувь)	Ерөнхий үнэлгээний дундаж (хувь)
Бодлогын үр дүн	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн	100	100
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	-	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	88.9	92.6
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	96.3	
Байгууллагын чадамжийн үнэлгээ	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100	100
Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт	-	-
	Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ	-	
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	-	
	Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт	93.3	
	Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн	-	
	Байгууллагын шудрага байдлын үнэлгээ	80	

	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	94	
	Хэрэглэгчийн үнэлгээ	-	
Нийт оноо	97.9 (5 оноо)		

ДӨРӨВ. БОДЛОГЫН ҮР ДҮН

4.1. Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 онд 1 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь 100 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

“Монгол Улсын удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ” зорилтын хүрээнд гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт хийх шалгуур үзүүлэлт 100 хувийн хэрэгжилттэй байна. (хүснэгт 2)

Хүснэгт 2.

Д/д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Дундаж хувь	Дундаж хувь
				2024 он	2025 он
1. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого					
1	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	100%	100%

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДҮН

5.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль 4, Улсын Их Хурлын тогтоол 3, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 1, Засгийн газрын тогтоол 18, Засгийн газрын албан даалгавар 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 19,

Ерөнхийлөгчийн зарлиг 1, нийт 49 шийдвэрийн 80 зүйл, заалтыг хэрэгжүүлэн ажилласныг хяналтад авав. (Хүснэгт 2.)

Дээрх 49 шийдвэрийн 80 зүйл, заалтаас “хэрэгжсэн” буюу 100 хувьтай 72 зүйл, заалт, “хэрэгжээгүй” буюу тухайн шийдвэрээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил, боловсруулалтын шатандаа байгаа, төсөв шийдэгдсэн боловч зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй 6 зүйл, заалт, “хугацаа болоогүй” буюу шийдвэрт тусгайлан заасан хугацаа болоогүй эсхүл өөрөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бусад хүчин зүйлээс шалтгаалсан 3 зүйл, заалт нийлбэр үнэлгээгээр 96.3 хувь үнэлэгдлээ.

Хүснэгт 3.

Шийдвэрийн төрөл								
Бүгд		Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
Шийдвэрийн тоо		49	4	3	1	18	19	3
Заалтын тоо		80	8	3	1	19	25	22
ҮНЭЛГЭЭ	Хэрэгжсэн (100%)	72	6	3	1	16	23	22
	Хэрэгжээгүй (100%-иас доош)	6	2	-	-	1	2	-
	Чиг үүрэгт хамаарахгүй	1	-	-	-	1	-	-
	Хугацаа болоогүй	1	-	-	-	1	-	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт нь 2025 оны жилийн эцсийн байдлаар дээрх 80 зүйл, заалтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.2. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам” болон Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөснөөс 44 арга хэмжээ буюу 80 хувь нь “бүрэн хангалттай”, 4 арга хэмжээ буюу 7.2 хувь нь “хангалттай” бол 70 хүртэл хувийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” 7 арга хэмжээ нь 12.7 хувийг тус тус эзэлж байна.(Хүснэгт 4, График 1.)

Хүснэгт 4.

Нийт арга хэмжээ-ний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Нийт үнэлгээ (хувиар)
	Бүрэн хангалттай 85 буюу түүнээс дээш хувь	Хангалттай 70-85 хүртэл хувь	Хангалтгүй 70 хүртэл хувь	
55	44	4	7	88.9

График 1.



Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан ажлууд хамгийн үр дүнтэй буюу 100 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан ажлууд 84.8 хувь, “Инновацад суурилсан цахим

шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан ажлууд 88.1 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 5)

Хүснэгт 5.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ			Дундаж хувь
			85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
1	2	3	4	5	6	7
1	Зорилт 1.Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	2	2	-	-	100
2	Зорилт 2.Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.	11	11	-	-	100
3	Зорилт 3. Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	34	26	2	6	84.8
4	Зорилт 4. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.	8	5	2	1	88.1
	Нийт	55	44	4	7	93.2

Байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 88.9% дүгнэгдлээ. Энэ нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

6.1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт:

Байгууллагын 2025 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр 69 сургалт, семинарыг зохион байгуулснаас дотооддоо 53, бусад байгууллагын 16 сургалтад давхардсан тоогоор 333 албан хаагчийг хамруулсан. Гадаад улсад зохион байгуулагдсан хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлийн 16 сургалт, семинарын арга хэмжээнд 63 албан хаагч мөн хамруулж 9.5 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Мөн Өмнөд бүс дэх газар нь орон нутгийн төсвөөс 1 албан хаагчид 6.0 сая төгрөг, 1 албан хаагчид гэр олгуулжээ.

Улсын төсвийн урсгал зардлаас төвд уулзалтын өрөө, хурлын заал болон зарим өрөөний засварт 28.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төв байрны цонх, гадна фасад, гражийн шал зэрэг засвар үйлчилгээнд 445.2 сая төгрөг зарцуулсан.

Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц шинжилгээнд 10 удаа 270 албан хаагчийг хамруулсан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийж, дүнг “Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалаар тооцож үнэлэхэд ерөнхий үнэлгээ 97.5 хувь, 5 оноотой дүгнэгдсэн нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 0.3 оноогоор өссөн үзүүлэлттэй байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээг “Эс Ай Си Эй” ХХК-тай 2024 оны 01/08-19 дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр гэрээлэн гүйцэтгүүлж, 3.5-4.2 оноотой буюу “сэтгэлт ханамж сайн, санаа зовох зүйлтэй” гэж дүгнэгдсэн.

Иймд зохион байгуулалтын нэгжүүд 2026 оны үйл ажиллагааны төлөвлөлт, шалгуур үзүүлэлтэд анхаарч “бүрэн хангалттай” хэдий ч үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа оны холбогдох төлөвлөгөөнд тусган үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, биелэлтийг бүрэн хангаж, үр дүнтэй ажиллах шаардлагатай.

--oo0oo--